



**“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

**ИНТЕРНЭТ СҮЛЖЭЭНИЙ ТОНОГЛОЛ НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: Интернэт сүлжээний тоноглол нийлүүлэх

Тендерийн дугаар: **ЦДҮС/202001149**

**УЛААНБААТАР ХОТ
2020 ОН**

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Интернэт сүлжээний тоноглол нийлүүлэх” нийлүүлэгчийн тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 30,000 /гучин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендерийг 2020 оны 03 дугаар сарын 13-ны 09:00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг Улаанбаатар хот-36 Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45 “ЦДҮС” ТӨХК-ний байр 3 дугаар давхар 309 тоотод 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 09:10 цагт тендерийг нээнэ.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот-21013, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн
өргөн чөлөө-45, “ЦДҮС” ТӨХК-ийн төв байр, 3 дугаар давхар, 309
тоот
Худалдан авах ажиллагаа, ханган нийлүүлэлтийн хэлтэс
Утас: 99039494**

Нэг. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
5. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. **Алдааг залруулах**
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
 - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;

(б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;

(в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Хоёр.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> - Сүүлийн нэг жил буюу 2019 оны санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/; - Сүүлийн хоёр жилийн ижил төстэй ажил хийсэн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, гэрээний акт гүйцэтгэл/; - Улсын бүртгэлийн гэрчилгээ; /нотариатаар баталгаажуулна/ - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт - Шүүхийн төрөлжсөн архивын лавлагаа ирүүлнэ. - Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн эсэх талаар захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тодорхойлолт ирүүлнэ. - Татварын цахим тодорхойлолт. - Харилцагч банкны хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тодорхойлолт./Улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх банк тус бүрээр/ - Монгол улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. /Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өрийг шалгахад өртэй байвал уг тендерээс татгалзах үндэслэл болно./ - Чанарын удирдлагын ИСО сертификат бүхий үйлдвэрийн бүтээгдэхүүн санал болгоно. - Сонгосон бараа материал, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн зөвшөөрөл, итгэмжлэл, техникийн тодорхойлолт, дэлгэрэнгүй танилцуулга - Компанийн дэлгэрэнгүй танилцуулга. - Тендерийн хэл Монгол хэл дээр байна. <p>Жич: Дээрх баримт бичгийн аль нэгийг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.</p> <p>Огноо: Тендерийг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр цахим системээр илгээх</p> <p>Цаг: 09 цаг 00 минут.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот-21013, Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45, “ЦДҮС” ТӨХК-ийн төв байр.</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 3-н давхар, 309 тоот</p> <p>Огноо: 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр</p> <p>Цаг: 09 цаг 10 минут</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p>“Интернэт сүлжээний тоноглол нийлүүлэх”</p> <p>ЦДҮС/202001149</p>
Бусад:	<p>Хөнгөлөлт урамшуулал үзүүлэх бол албан бичгээр ирүүлнэ.</p>

Гурав. БАРААНЫ ЖАГСААЛТ БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Газрын шилэн кабель булдаг 48 корийн	GYTA53	м	1600	"ЦДҮС" ТӨХК-ийн Төвийн бүсийн салбар	14	21	
Төгсгөлийн төхөөрөмж 48 корийн FDF	ODF 48core	ш	2				
Медиа конвертер	СТС 1000 10км	хос	3				
Тог баригч /UPS/ out 4	3600Вт	ш	1				
SFP модуль	25км 1.25gb	ш	4				
Бичигч төхөөрөмж NVR 32ch		ком	1				
Утасгүй сүлжээ цацагч	Ubiquiti UAP-AC-SHD	ш	6				

Тэжээлийн инвертор	2000W	ш	1				
Дэлгэц 27 инч	Dell	ш	4				
Утасгүй сүлжээ хүлээн авагч	2.4GHz, 5GHz 150mbps	ш	30				
Кондейшн		ш	2				
Рак шкаф	42unit	ш	1				
POE свич 8 порт 1гб		ш	8				
POE свич 16 порт 1гб		ш	4				
Камерийн удирдлагын JoyStick Гар пультны хамт		ком	1				
Сүлжээ хяналтын компьютер i7 дэлгэц 27 инч	dell	ш	1				
Монитор 42 inch LCD 4K		ш	1				
Салаалагч свич	1gb 8port	ш	10				
Тэжээлийн залгуур PDU	toten 8 in 25A	ш	6				
Сүлжээний кабель e6 /STP/	Cate6	м	2400				

Жампер коннектор	SC-FC	ш	32				
Жампер кабель	SC-SC	ш	138				
Жампер кабель	SC-FC 30м	ш	8				
Жампер кабель	FC-FC 3м	ш	8				
Шилэн кабелийн оролттой свич POE той	1gb 24 port 2sfp port	ш	1				
Далдлагч хоолой	d-22mm	м	200				
Далдлагч хоолой	d-26mm	м	1500				
Тэжээлийн блок	12В, 5В	ш	1				

Баглаа боодол: Чанар, стандартын шаардлагад нийцсэн байна.

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

“ЦДҮС” ТӨХК-ийн Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженерийн баталсан “Интернэт сүлжээний тоноглол нийлүүлэх” ажлын техникийн шаардлагыг энэхүү тендерийн баримт бичигт хавсаргав. Энэхүү техникийн тодорхойлолт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болно.

220/110/35кВ-н Дархан дэд станцын интернет сүлжээ, Төвийн бүсийн салбарын конторын интернет сүлжээ, 110кВ-н ХХБ дэд станц – Контор хоорондын шилэн кабель солих их засварын ажлын материалын техникийн шаардлага

2020.02.19

Газрын шилэн кабелийн тодорхойлолт

Д/д		Үзүүлэлт
1	Ерөнхий шаардлага	Газар булах зориулалттай ус чийгэнд тэсвэртэй материалаар хийгдсэн, гол хэсэгтээ металл ган бэхэлгээ орсон давхар хамгаалалтын бүрээстэй кабель байна.
1	Model	GYTA53 Outdoor Cable – тэй дүйцэхүйц
2	Certification	RoHS, CE, ISO9001
3	Sheath Material	Lszh, HDPE, MDPE
4	Installation Style	Duct & Direct Buried
5	Уналтын алдагдлын түвшин	Бара 1км - ~0.22db
6	Operation temperature	-60 deg C to + 70 deg C
7	Installation temperature	-30 deg C to + 60 deg C
8	Transport and storage temperature	-40 deg C to + 75 deg C
9	Fiber Count	48
10	Brand	OEM or Tw-Scie
11	Loose Tube Material	PBT Optic Fiber Cable
12	Waterblocking Material	Water Blocking Tape or Filling Compound
13	Outer Sheath Material	MDPE / HDPE /Lszh

Шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмжийн тодорхойлолт

Д/д		Үзүүлэлт
1	Ерөнхий шаардлага	19инч рак хайрцагны зориулалттай стандарт төгсгөлийн төхөөрөмж байх. Дагалдах хэрэгслийн хамт
2	Model	Rack mounted ODF, 48core – тэй дүйцэхүйц
3	Дагалдах хэрэгсэл	C/UPC Single Mode simplex adapters & SC/UPC Single Mode simplex, 0.9mm 1M pigtails
4	Бусад шаардлага	3 жилийн баталгаа

Медиа конвертерын тодорхойлолт

Д/д		Үзүүлэлт
1	Ерөнхий шаардлага	24/7 ажиллагаатай
2	Модель	СТС FIB1-E1R-SC20A,B- тэй дүйцэхүйц
3	Интерфейс	RJ45 copper IEEE 802.3 10Base-T
4	Хамгаалалт	WEP, WPA-PSK, WPA-TKIP, WPA2 AES, 802.11i
5	Дамжуулах чадал	10/100/1000mbps
6	Долгионы урт	TX: 1310nm RX: 1550nm
8	Баталгаат хугацаа	1 жил

Тог баригч /UPS/-ийн техникийн тодорхойлолт

Д/д		Үзүүлэлт
1	Ерөнхий шаардлага	24/7 ажиллагаатай хүчдэл тасарсан үед бүрэн чадлаараа 60 минут ажиллах чадвартай байх.
2	Стандарт	EN 50091-1, EN 50091-2, GOST
3	Model	APC Smart UPS XL- тэй дүйцэхүйц
4	Хүчин чадал	3000ВА-3600ВА, 2300 - 2500Ватт
5	Хяналтын оролт гаралтын порт	Стандарт RJ-45, DB9, rs232
6	Оролтын хүчдэл	220 - 240В хувьсах
7	Оролтын давтамж	47-53Hz
8	Гаралтын хүчдэл	220В хувьсах
9	Гаралтын давтамж	50Hz
10	Ажиллах хугацаа	60+минут
11	Хүчдэл шилжилтийн хугацаа	2мс – 4мсекунд хүртэл
12	Баталгаат хугацаа	1 жил
13	Дагалдах хэрэгсэл	Оролтын тэжээлийн кабель 2ш, Гаралтын тэжээлийн кабель гаралтын портны тоогоор дагалдах

SFP модулийн тодорхойлолт

Д/д		Үзүүлэлт
1	Ерөнхий шаардлага	SC оролттой
2	Model	SFP BiDi 1G SC- тэй дүйцэхүйц
3	Чадамж	1.25Gbps нэвтрүүлэх чадамжтай.
4	Горим	Single mode горимоор 10км хүртэл зайд дамжуулна.
5	Долгионы урт	Долгионы урт нь 1550TX/1310RX

6	Холболт	SC коннектортой.
7		

Бичигч төхөөрөмж /NVR/-ийн тодорхойлолт

Д/д		Үзүүлэлт
1	Ерөнхий шаардлага	24/7 ажиллагаатай
2	Модель	CP-UNR-7364R8-R- тэй дүйцэхүйц
3	Техникийн шаардлага	H.264/MJPEG dual codec decoding Max 256Mbps incoming bandwidth HDMI / VGA simultaneous video output Support 8 SATA HDDs up to 32TB, 1 eSATA up to 16TB, 4 USB2.0 Support RAID 0, RAID 1, RAID 5, RAID 6, RAID 10 Support Multi-brand network cameras ONVIF Version 2.2 conformance Mobile Software: CMOB CMS Software: KVMS
4	Үндсэн үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> • ProcessorDual-core embedded processor • Operating SystemEmbedded LINUX • IP Camera Input64 channel • Two-way Talk1 channel Input, 1 channel Output, RCA • User InterfaceGUI • Video Output2 HDMI, 1 VGA, 1TV • CompressionH.264 / MJPEG • Video Resolution1920 x 1080, 1280 x 1024, 1280 x 720, 1024 x 768 • Video RecordingMax 192 Mbps • Video Display Split1/4/8/9/16/25/36 • Motion DetectionMD Zones: 396(22*18). • Video LossSupports • Camera BlankSupports • Alarm Input16 channel • Alarm Output6 channel • Hard Disk8 SATA ports (8HDDs or 6HDDs+1CD/DVD-RW), up to 32TB, Raid (redundancy), 1 eSATA port (Max 4 SATA HDDs), up to 16TB • Trigger EventsRecording, PTZ, Tour, Alarm, Video Push, Email, FTP, Spot, Buzzer & Screen • Recording ModeManual, Schedule(Regular(Continuous), MD, Alarm), Stop • Search ModeTime/Date, Alarm, MD & Exact search (accurate to second), Smart search • PlaybackPlay, Pause, Stop, Rewind, Fast play, Slow play, Next file, Previous file, Next camera, Previous camera, Full screen, Repeat, Shuffle, Backup selection,Digital zoom

		<ul style="list-style-type: none"> • Backup Mode USB Device / eSATA Device / Internal SATA burner/ Network • Interface Ports 2 HDMI, 1 VGA, 1 TV, 4 USB 2.0, 1 RS485, 1 RS232, 2 RJ45 • Max User Account 128 users • Record Interval 1~120 min (default: 60 min), Pre-record: 1~30 sec, Post-record: 10~300 sec • Smart Phone iPhone, iPad, Android, Windows Phone • Protocols HTTP, TCP/IP, IPv4/IPv6, UPNP, RTSP, UDP, SMTP, NTP, DHCP, DNS, IP Filter, PPPOE, DDNS, FTP, Alarm Server, ONVIF Version 2.2 • Ethernet 2 RJ-45 port (10/100M/1000M) • Power Supply AC 100~240V, 50/60 Hz • Power Consumption 75W (without HDD) • Working Temp -10 ~ +55°C / 10~90%RH / 86~106kpa • Dimensions 440mm Ч 460mm Ч 89mm • Weight 6KG (without HDD)
8	Баталгаат хугацаа	1 жил

Утасгүй сүлжээ цацагчийн тодорхойлолт

Д/д		Үзүүлэлт
1	Ерөнхий шаардлага	24/7 ажиллагаатай
2	Model	Ubiquity UniFi AP Long range – тэй дүйцэхүйц
3	Стандарт	802.11 b/g/n 2.4 GHz
4	Хамгаалалт	WEP, WPA-PSK, WPA-TKIP, WPA2 AES, 802.11i
5	Дамжуулах чадал	27 dBm
6	Холбогдох хэрэглэгч	Нэгэн зэрэг 100 хүртэл
7	Дамжуулалтын хурд	6.5 Mbps to 300 Mbps (MCS0 - MCS15, HT 20/40)
8	Баталгаат хугацаа	1 жил

Инверторын техникийн тодорхойлолт

Д/д	Загвар	ҮКДА-HD2000 -тай дүйцэхүйц
1	Чадал	1500 Вт
2	Тогтмол оролт	Оролтын хүчдэл
3		Оролтын гүйдэл
4		Унтрах хүчдэлийн хязгаар
5		Ажиллах хүчдэлийн хязгаар
6		Хувьсах оролт
		220В /DC/ 4.5А 180В—275В 208В—260В 260В-180В (±10В)

7		Оролтын гүйдэл	4.5A
8		Шилжилтийн хугацаа	≤5 мс
9	Хувьсах гаралт	Гаралтын хүчдэл ба давтамж	220Vac, 50Hz
10		Долгионы хэлбэр	Синусойд
11		Гаралтын гүйдэл	3.6A
12		Гаралтын хүчдэлийн нарийвчлал	220В ± 1.5%
13		Гаралтын давтамжийн нарийвчлал	50Гц ± 0.1%
14		Долгионы хазайлт	≤3% (шугаман ачаалал)
15		Хариу үйлдэл үзүүлэх хугацаа	5% (ачаалал 0←→100%)
16		Чадлын коэффициент	0.7/0.8
17		Хэт ачаалагдах чадвар	120%, 30 секунд
18		Ашиг үйл	≥ 85%
19	Тусгаарлагын хүчдэл чадвар	1500В, 1 мин	
20	Чимээ (1м)	≤ 40dB	
21	Ажиллах температур	-5°C ~ 40°C	
22	Чийгшил	0~90%	
23	Далайн төвшнөөс дээш	≤ 1000m	
24	Хамгаалалтын функц	Оролтын хүчдэлийн ихсэлт/бууралт, хэт ачаалал, богино залгаа, хүчдэл ихсэлт/бууралтын хамгаалалт	
25	Хийц	Рак буюу панель суурилах боломжтой байх	

Хяналтын дэлгэцийн техникийн тодорхойлолт

Д/д		Үзүүлэлт
1	Ерөнхий шаардлага	Өнгө дүрсний нягтрал сайтай бат бөх байх.
2	Model	DELL SE2719H / 27" IPS LED Monitor– тэй дүйцэхүйц
3	Дэлгэцийн харьцаа	16:9
4	Нягтаршил	1920 x 1080 at 60 Hz
5	Контраст	100,000,000:1
6	Харагдах өнцөг (босоо/хэвтээ)	178/178 градус
7	Оролт	VGA, HDMI (VGA, HDMI кабель багтаана)
8	Баталгаат хугацаа	3 жил
9	Бусад шаардлага	Тэжээлийн залгуур болон хананд тогтоогч дагалдах хэрэгсэл багтсан байна.

Утасгүй сүлжээ хүлээн авагчийн тодорхойлолт

Д/д		Үзүүлэлт
1	Ерөнхий шаардлага	24/7 ажиллах
2	Модель	TP-Link USB Wifi Adapter for PC N150 Wireless Network Adapter for Desktop – тэй дүйцэхүйц
3	Стандарт	802.11 b/g/n 2.4, 5GHz
4	Хамгаалалт	WEP, WPA-PSK, WPA-TKIP, WPA2 AES, 802.11i
5	Дамжуулах чадал	150mbps
6	Систем	10/7/8/8.1/XP/Mac OS 10.9-10.15 Linux Kernel 2.6.18-4.4.3
8	Баталгаат хугацаа	1 жил

Air Condition-ий техникийн тодорхойлолт

Д/д		Үзүүлэлт
1	Ерөнхий шаардлага	24/7 ажиллах, хүйтэн халуун үлээдэг
2	Model	BSB AC-18GSWJ Air Con – тэй дүйцэхүйц
3	Хэмжээ	18,000BTU
4	Ажиллагаа	Халуун хүйтнээр үлээнэ
5		Сэнсний хурд тохируулагчтай
6		Шөнийн ажиллагааны горимтой
7		Лед дэлгэцтэй
8		Нэмэлт халаагчтай
9	Чадал	Хөргөх хүчин чадал 18000Вт / 56м2 Халаах хүчин чадал 18500Вт / 28м2
10	Сэлгэх агаарын хэмжээ	800м3/цагт
11	Хэрэглэх хүчдэлийн чадал давтамж	220-240В, 50Hz
12	Бусад шаардлага	Дуу чимээ багатай
13	Баталгаат хугацаа	1 жил

Сүлжээний зогсуурын тодорхойлолт

Д/д		Үзүүлэлт
1	Ерөнхий шаардлага	Төмөр сайтай 42unit-аас дээш хар өнгийн зөвхөн нэг талдаа шилэн хаалгатай дугуйтай давхар тулаастай 4 талаараа онгойлгож үйлчилгээ хийх боломжтой байхаар.
2	Model	APCE 42U раk – тэй дүйцэхүйц
3	Хэлбэр хэмжээ	Шилэн хаалгатай, 4 сэнстэй, 2 тавцантай. Өндөр: - 42unit Гүн : 800мм буюу 80см Урт : 600мм буюу 60см
4	Дагалдах хэрэгсэл	Төхөөрөмж бэхлэх боолт гайх хэрэгслийг бүрэн дагалдуулах бэхэлгээ хий үүрийн тоогоор

POE switch-ийн техникийн тодорхойлолт

Д/д		Үзүүлэлт
1	Ерөнхий шаардлага	24/7 ажиллагаатай
2	Модель	TL-SG1008PE, TL-SG1016PE – тэй дүйцэхүйц
3	Интерфейс	Switch with 110W 8-16 PoE Ports
4	Гадна байдал	Desktop/Rackmount
5	PoE чадал	126W
6	QoS	802.1p/DSCP
8	Баталгаат хугацаа	1 жил

Joystick Control-ийн техникийн тодорхойлолт

Д/д		Үзүүлэлт
1	Үндсэн шаардлага	Камер бичигч төхөөрөмж болон сүлжээнд холбогдох камертай техник хангамжын болон програм хангамжын хувьд цохицон ажилладаг байх.
2	Модель	CPPlus CP-UNK-331 PTZ гар– тэй дүйцэхүйц
3	Техникийн шаардлага	3 Dimensional of PTZ Functions, Preset Position, Auto Scan, Auto Pan, Auto Tour & Pattern Control, Network Video Server, On-Screen Menu & User Operation Procedure Tips, Connect KVMs Pro via USB
4	Үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> • Keyboard Keypanel Electromechanical • Joystick 3-axis, vector-solving, with twisting, return to-center head

	<ul style="list-style-type: none"> • Keyboard Connector RJ-45, RS232, RS485, RS422, USB • Network Model Interface: RJ45 DVR/Network Dome: IP Address/Port/Protocol • Keyboard Communication Direct Mode, Network Mode • Power Consumption 5W • Resolution LCD, 75.2mm x 33.85mm • Direct Model Interface: RS232/RS485 • Display 1/4/8/9/16 • Power Supply Power adapter, input 100V~240V 50Hz / 60Hz, output DC 12V/1000mA • Working Temp -10~+55°C • Working Humidity 10%~90% • Atmosphere Pressure 86kpa~106kpa • Weight 2.5Kg • Dimension 330mm x 160(140)mm x 37.5(21)mm (WЧ ДЧН) (height: 100mm including)
--	--

Хяналт операторын компьютер

Д/д		Үзүүлэлт
1	Ерөнхий шаардлага	24/7 тасралтгүй ажиллах чадвартай
2	Model	Dell OptiPlex 9020 – тэй дүйцэхүйц
3	Процессор	4.0GHz
4	CPU	Intel Core i7
5	Generation	7 th - 8 th хэмжээнд
6	RAM	16GB DDR
7	HDD Хатуу диск	1TB SSD 4tb HDD
8	ODD Оптик драйв	DVD+/-RW
9	Дэлгэц	27 inch FULL HD DELL SE2719H / 27" IPS LED Monitor – тэй дүйцэхүйц
10	Graphics	Nvidia GTX1080ti ddr5 4 gb
11	Дотоод сүлжээний хурд	Integrated Giga bit 10/100/1000 Ethernet 1 оролттой
12	USB оролт	Usb 2.0/usb 3.0 дэмждэг 4 оролт
13	Үйлдлийн систем	Windows 10 Pro
14	Баталгаат хугацаа	3 жил
15	Дагалдах хэрэгсэл	Механик Гар, Хулгана, Пад
16	Дэлгэцийн гаралт	VGA 1 гаралттай, HDMI 2 гаралттай

Хяналтын камерын дэлгэцийн техникийн тодорхойлолт

Д/д		Үзүүлэлт
1	Ерөнхий шаардлага	Өнгө дүрсний нягтрал сайтай бат бөх байх.
2	Model	Sony KDL-43W800F Full HD HDR– тэй дүйцэхүйц
3	Дэлгэцийн харьцаа	16:9
4	Нягтаршил	1920 x 1080 at 60 Hz
5	Контраст	100,000,000:1
6	Харагдах өнцөг (босоо/хэвтээ):	178/178 градус
7	Оролт	VGA, HDMI – 1,2,3 (VGA, HDMI кабель багтаана)
	Техникийн үзүүлэлт	ON-BOARD STORAGE 16 GB HIGH DYNAMIC RANGE Dynamic Contrast Enhancer Motionflow™ XR 200 (Native 50Hz) Дуугаралт 5+5Вт /Bass Reflex Speaker/ SMARTPHONE холболт - Screen mirroring(Miracast™), Chromecast built-in, Video & TV SideView (iOS/Android) AUDIO/HEADPHONE OUTPUT(S) USB x 3
8	Баталгаат хугацаа	3 жил
9	Бусад шаардлага	Тэжээлийн залгуур болон хананд тогтоогч, дагалдах хэрэгсэл багтсан байна.

Жампер, коннекторын техникийн тодорхойлолт

Д/д		Үзүүлэлт
1	Ерөнхий шаардлага	Стандарт SC – FC толгойтой байх
2	Model	Fiber Optic Adapter FC-SC Hybrid Converter Coupler– тэй дүйцэхүйц
4	Оруулгын алдагдал	0,20db
5	Буцах алдагдал	50db – багагүй байх
6	Техникийн үзүүлэлт	Item Type: FC Male to SC Female Fiber Optic Adapter Insertion Loss (dB): 1310nm (≤0.3), 1550nm (≤0.3) Return Loss (dB): 1310nm (≥60), 1550nm (≥60) Interchangeability (dB): ≤0.20 Operating Temperature: -25°C ~ +75°C Storage Temperature: 25°C ~ +75°C

Жампер кабелийн тодорхойлолт

Д/д		Үзүүлэлт
1	Ерөнхий шаардлага	Стандарт SC – SC, SC – FC, FC-FC толгойтой байх
2	Model	Fiber Patch Cable G657A– тэй дүйцэхүйц
3	Урт	3-5метр байх
4	Оруулгын алдагдал	0,3db
5	Буцах алдагдал	50db – багагүй байх
6	Орчны температур	-45 - + 85 целс

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

**Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал
Б.Нямсамбуу танаа**

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Баталгаат засварын хугацаа 1 жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |

**11. Маргааныг
шийдвэрлэх**

11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа.ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. Барааг хүлээн авахаас өмнө мэдээлэл технологийн хэлтсээр шалгуулж туршилт хийлгүүлнэ.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- Чанарын баталгаат хугацаа 06 сар байна.
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **95** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн дагуу
- Урьдчилгаа төлбөр олгож болно.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн дагуу Урьдчилгаа төлбөр төлж болно. Урьдчилгаа төлбөрийг маягтын дагуу харилцагч банкны баталгааг үндэслэн урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргасан дүнгээр олгоно.
- Харилцагч талуудын хооронд хийгдсэн бараа, ажил, үйлчилгээ, мөнгөн гүйлгээг тухайн жилийн 2-р дугаар улирал болон жилийн эцсийн байдлаар тодруулж хоорондын тооцооны үлдэгдлийг Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу баталгаажуулна.Тооцооны үлдэгдлийг талуудын хооронд үүссэн данс тус бүрээр баталгаажуулж хөтөлнө.

**5. Алданги
оногдуулах
(ГЕН - 9)**

9.1. Алданги оногдуулах хувь: Гэрээний үнийн **0.05%** байна.
Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн **5%**-иас хэтрэхгүй.

Долоо. **ГЭРЭЭНИЙ МАЯГТ¹**

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]